Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН, 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1. Монгол Улсын хөгжлийн болон эрүүл мэндийн бодлого, хууль, тогтоомжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх** | | | | | | | | |
| 5 | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Үнэлгээний дүн болон дээд шатны байгууллагын үнэлгээний зөрүү <5% | Сар бүр үнэлгээ хийж, тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, цахим мэдээллийн санд оруулдаг | Тайланг хугацаанд нь Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, цахим мэдээллийн санд оруулсан байна. | II, IV улирал | ХШҮДАГ С.Энхжин | 1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2025.01.24-ний өдрийн 2/433 дугаар албан бичгээр, ЗГХХГ-т хүргүүлсэн. Үнэлгээний дүн 14.3% байна.<br>2. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан боловсруулсан. Үнэлгээний дүн ..... хувь байна. Дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 1а/..... дугаар албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулсан. | **100.0** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх | Үнэлгээний дүн болон дээд шатны байгууллагын үнэлгээний зөрөө <5% | Сар бүр үнэлгээ хийж, тайланг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж, цахим мэдээллийн санд оруулдаг | Тайланг хугацаанд нь Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, цахим мэдээллийн санд оруулсан байна. | II, IV улирал | ХШҮДАГ Н.Отгонжар-гал | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, тайлан боловсруулсан. Үнэлгээний дүн ..... хувь байна. Дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 1а/..... дугаар албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулсан. | **100.0** |
| 7 | Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд 2024 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх | Хяналт-шинжилгээ-ний тайлан | Жил бүр үнэлгээ хийж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, цахим мэдээллийн санд оруулдаг | Дүнг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хугацаанд нь хүргүүлж, цахим мэдээллийн санд оруулсан байна. | I улирал | ХШҮДАГ Д.Дэмбэрэл-даваа | Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд 2024 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийсэн. Үнэлгээний дундаж 75.5 хувьтай байсан. Дүнг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн санд хугацаанд оруулж, 8/2405-2427 дугаар албан бичгээр Аймаг, нийслэлийн ЗДТГ-т хүргүүлсэн. | **100.0** |
| **Зорилт 2. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх** | | | | | | | | |
| 8 | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх | Хяналт-шинжилгээ-ний тайлан | Журамд заасан хугацаанд тайланг цахим мэдээллийн санд оруулдаг | Журамд заасан хугацаанд тайланг цахим мэдээллийн санд оруулсан байна. | I-IV улирал | ХШҮДАГ С.Эрдэнэ-туяа | 2024 оны жилийн эцэст 202 шийдвэрийн 423 зүйл, заалт (МУ-ын хуулийн зүйл, заалт 56, УИХ-ын тогтоол 64, УИХ-ын Байнгын хорооны тогтоол 56, Ерөнхийлөгчийн зарлиг 7, ЗГ-ын тогтоол 69, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл 140, ЗГ-ын албан даалгавар 16, ҮАБЗ-ийн зөвлөмж 15)-аар өгсөн үүрэг, даалгаврын | **100.0** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэгжилтэд холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд оруулж, ЗГХХГ-т хууль тогтоомжийн заалтуудаас “бүрэн хэрэгжсэн”, “хамааралгүй” 67 заалтыг хасуулах саналыг 2025 оны 2/153 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>2025 оны 1 дүгээр сарын байдлаар Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавраар Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн яаманд үүрэг болгосон 133 шийдвэрийн 235 зүйл, заалтын хэрэгжилтэд холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулсан.<br>2025 оны 3 дугаар сарын байдлаар Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавраар Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн яаманд үүрэг болгосон 127 шийдвэрийн 196 зүйл, заалтын хэрэгжилтэд холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулсан.<br>ЗГХЭГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу Засгийн газрын шийдвэр, | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ерөнхий сайдаас эрүүл мэндийн чиглэлээр өгсөн шуурхай үүрэг даалгаврын биелэлтээс хангалтгүй, хэрэгжээгүй, удааширсан 17 шийдвэрийн 22 үүрэг даалгаврын хэрэгжилтэд 2025 оны 5 дугаар сарын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүн, тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд оруулж, ЗГХЭГ-т 2025 оны 2/2565 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Хууль, тогтоомжийн заалтуудаас "хэрэгжилт хангалтгүй", "хэрэгжээгүй", цаашид эрчимжүүлэх шаардлагатай байгаа заалтуудын хэрэгжилтийг сайжруулах талаарх ТНБД-ын "Дотоод меморандум"-ыг 2025 оны 1 дүгээр сарын 9, 2 сарын 19, 4 сарын 17-ны өдөр яамны холбогдох газруудад тус тус хүргүүлсэн. | |
| 9 | Засгийн газрын тогтоолоор баталсан хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ хийх | Хяналт-шинжилгээ-ний тайлан | Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Тайланг ЗГХЭГ-т хүргүүлэх | I-II улирал | ХШҮДАГ С.Эрдэнэ-туяа | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан Засгийн газрын шийдвэрээр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг хүлээсэн 15 хуулийн 27 заалтыг дагаж гарсан тогтоол, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг ЗГХЭГ, ХЗДХЯ-нд 2025 оны 2/3035 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | **100.0** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийх | Хяналт-шинжилгээ-ний тайлан | Жил бүр үнэлгээ хийж, ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулдаг | Дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулсан байна. | II улирал | ХШҮДАГ Н.Отгонжар-гал | Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2024 оны шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан боловсруулсан. Үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2024 оны шийдвэрийн биелэлт 77.9 хувьтай байна. | **100.0** |
| 11 | "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээ хийх | Үнэлгээний тайлан | - | Үнэлгээний тайлан | I улирал | ХШҮДАГ С.Энхжин | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар баталсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" 2021-2024 оны хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээ хийж, тайлан боловсруулсан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 69.0%, шалгуур үзүүлэлтийн биелэлт 46.9%-тай байна. Үнэлгээний дүнг тархаах уулзалтыг 2025.01.28-ны өдөр зохион байгуулж, дүнг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудын төлөөлөлд танилцуулсан. | **100.0** |
| 12 | "Ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний загварыг турших төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд /2022-2024/ үр нөлөөний үнэлгээ хийх | Үнэлгээний тайлан | - | Үнэлгээний тайлан | II улирал | ХШҮДАГ Д.Дэмбэрэл-даваа | "Ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний загварыг турших төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд /2022-2024/ үр нөлөөний үнэлгээ хийх удирдамжийг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тайлан, мэдээлэл ирүүлэх Дотоод | **50.0** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | меморандум №134-ыг холбогдох газруудад хүргүүлсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/127, А/333 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээ хийж, тайлан боловсруулж байна. | |
| **Зорилт 3. Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх** | | | | | | | | |
| 13 | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх | Үнэлгээний дүн болон дээд шатны байгууллагын үнэлгээний зөрөө <5% | Жил бүр үнэлгээ хийж, тайланг Сангийн яаманд хүргүүлдэг | Тайланг Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлж, цахим мэдээллийн санд оруулсан байна. | I улирал | ХШҮДАГ Н.Уранхайч | Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа 28 төсөл арга хэмжээний 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан боловсруулсан. Үнэлгээний хувь 81.8 байна. Тайланг 1а/1152 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | **100.0** |
| 014 | Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн PIMIS цахим системийн хөтлөлтөд хяналт тавих | Цахим системд байршуулсан мэдээллийн хяналт | - | Тайлагналын үнэн зөв, бүрэн байдал хангагдана. | I-IV улирал | ХШҮДАГ Н.Уранхайч | Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилтийн удирдлагын систем ODAMIS-д 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2.0 сая евро, 1.9 сая иен, 0.7 сая доллар, 20,578.0 сая төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг бүртгэн илгээсэн байна. Үүнээс 2.0 сая евро, 0.5 сая доллар, 18,502.0 сая төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг Сангийн яам баталгаажуулсан | **30.0** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. ODAMIS цахим программыг “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем-PIMIS” цахим хуудсанд нэгтгэхтэй холбоотой гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилтийн мэдээллийг бүрэн байршуулаагүй байна. ODAMIS болон PIMIS программын бүртгэл, мэдээлэлд хийсэн хяналтын тайланг Санхүү, эдийн засгийн газарт Дотоод меморандум хүргүүлэхээр бэлдэж байна. | |
| 15 | Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх | Хяналт-шинжилгээ-ний тайлан | - | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна. | II-IV улирал | ХШҮДАГ Н.Уранхайч | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/528 дугаар тушаалаар батлагдсан “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг боловсруулж байна. | **50.0** |
| **Зорилт 4. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх** | | | | | | | | |
| 16 | Эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ хийх | Хяналт-шинжилгээ-ний тайлан | Жил бүр үнэлгээ хийж, санал, зөвлөмж гардаг | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна. | I улирал | ХШҮДАГ Д.Дэмбэрэл-даваа С.Эрдэнэтуяа С.Энхжин Х.Өлзий-Орших Г.Туул Н.Уранхайч | Эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргаар 2025.01.03-ны өдөр батлуулсан. ЭМЯ-ны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, | **100.0** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тусгай мэргэжлийн төв, БОЭТ-үүд 66.5%-ийн гүйцэтгэлтэй, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрууд 68.8%-ийн гүйцэтгэлтэй, "Эрчимжүүлэх шаардлагатай" гэж үнэлэгдэв. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний дүн, санал, зөвлөмжийг 8/2075-2096, яамны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний дүнг 8/2306-2329 дүгээр албан бичгээр байгууллага тус бүрт хүргүүлсэн. | |
| 17 | Эрүүл мэндийн яамны 2024 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ хийх | Хяналт-шинжилгээ-ний тайлан | Жил бүр үнэлгээ хийж, тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, цахим мэдээллийн санд оруулдаг | Үнэлгээний дүнг хугацаанд нь цахим мэдээллийн санд оруулсан байна. | I улирал | ХШҮДАГ С.Энхжин | Эрүүл мэндийн яамны 2024 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан боловсруулсан. Үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Үнэлгээний дүнг 2/1077 дугаар албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулсан. ЭМЯ-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 62.3 хувь, Яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт 41.7 хувь, Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт 77.1 хувь тус тус байна. | **100.0** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 5. Төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах** | | | | | | | | |
| 19 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан "Дотоод аудитын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний дагуу санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх | Аудитын тайлан | Жил бүр дотоод аудитын төлөвлөгөө-ний дагуу санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийдэг | Дүгнэлт, санал, зөвлөмж хүргүүлсэн байна. | I-IV улирал | ХШҮДАГ Х.Өлзий-Орших Г.Туул | Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу 2025 оны эхний хагас жилд нийт 9 төлөвлөгөөт хяналт шалгалт, дотоод аудит хийж 81.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:<br>1. Санхүүгийн хяналт шалгалтыг чиглэлээр:<br>- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт;<br>- Хууль бус шийдвэрийн улмаас төрийн албанаас халагдсан ажилтнуудад нөхөн олговрыг хуулийн дагуу буруутай этгээдээр төлүүлсэн эсэхэд гүйцэтгэлийн аудит;<br>2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний дотоод аудит:<br>- Сэргээн засах төвийн барилга, 36 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/;<br>- Эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо, Гачуурт тосгон/;<br>- Вакцины хяналтын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/;<br>- Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо/; | **81.0** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Эрүүл мэндийн салбарын их засвар /улсын хэмжээнд/-Улсын хоёрдугаар төв эмнэлэг барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/;<br>- Эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/;<br>- Эрүүл мэндийн салбарын их засвар /улсын хэмжээнд/-Улсын нэгдүгээр төв эмнэлэг барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/. | |
| 20 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан "Дотоод аудитын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний дагуу төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх | Аудитын тайлан | Жил бүр дотоод аудитын төлөвлөгөө-ний дагуу дотоод аудит хийдэг | Дүгнэлт, санал, зөвлөмж хүргүүлсэн байна. | I-IV улирал | ХШҮДАГ Н.Уранхайч | Төсөл хөтөлбөр, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн дотоод аудитаар эхний хагас жилд 6 арга хэмжээ төлөвлөснөөс 5 төсөл арга хэмжээнд хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийж 83.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:<br>- Түлэнхийн төв байгуулах төсөл;<br>- Глобаль сангийн дэмжлэгээр 2024-2025 онд хэрэгжүүлсэн ДОХ, сүрьеэгийн төслийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж;<br>- Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл арга хэмжээний мэдээллийн ODAMIS цахим системийн хөтлөлтөд хяналт тавих;<br>- "Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл (P173799)"- | **83.3** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ийн хэрэгжилтийн үр нөлөөний хөндлөнгийн үнэлгээ;<br>- Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэсэн. | |
| 21 | Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн дагуу Дотоод аудитын 2024, 2025 оны үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад тайлагнах | Тайлан | Тайланг Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлдэг | Тайланг Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн байна. | I, III улирал | ХШҮДАГ Х.Өлзий-Орших Н.Уранхайч | Эрүүл мэндийн яамны Дотоод аудитын 2024 оны үйл ажиллагааны тайланг жилийн эцсийн байдлаар 2025.01.08-ны өдрийн 2/134 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн. | **100.0** |
| 22 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих | Шилэн дансны мэдээлэл | Сангийн яамны https//shilendans.gov.mn.reportorgs цахим санд мэдээллийг байршуул-даг | Цахимд санд мэдээлэл байршуулсан байна | I-IV улирал | ХШҮДАГ Г.Туул | ЭМЯ-ны ажлын байрны үндсэн чиг үүрэг шинэчлэн батлагдсантай холбоотойгоор ТНБД-ын 2025 оны А/07 тушаалаар цахим хуудсанд мэдээлэл байршуулах журмыг шинэчилэн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлуулсан.<br>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар яамны цахим хуудсанд нийт 113 мэдээлэл байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроон | **100.0** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байршуулсан, 7 мэдээлэл цахим санд байршуулаагүй байсанд Санхүү, эдийн засгийн бодлогын газарт 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Дотоод меморандум №200-ыг хүргүүлсэн.<br>ЭМЯ-ны цахим санд 1 дүгээр улирлын байдлаар 106 мэдээлэл байршуулсан байна. | |
| 23 | Үндэсний аудитын газраас 2020-2024 онд эрүүл мэндийн салбарын хэмжээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа, хөтөлбөр, санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах | Аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын нэгтгэл | "Санхүүгийн тайлангийн аудит"-аар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг баталгаа-жуулдаг | "Санхүүгийн тайлангийн аудит"-аар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг баталгаажуу-лан https://fas.audit.mn цахим санд бүртгүүлсэн байна. | I-IV улирал | ХШҮДАГ<br>Г.Туул<br>С.Энхжин | Үндэсний аудитын газраас эрүүл мэндийн салбарын хэмжээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа, хөтөлбөрт 2020-2024 онд хийгдсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд явцын хяналт хийж байна. 2020-2024 оны хугацаанд хууль, бодлого, тогтолцоо, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, сан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд ойролцоо 43 гүйцэтгэлийн, нийцлийн, санхүүгийн тайлангийн аудит тус тус хийгдсэн байна.<br>"Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн" сэдэвт аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тайланг 2025.02.12-ны өдрийн 2/798 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.<br>ҮАГ-аас "Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө"-д 2024 онд хийсэн гүйцэтгэлийн аудитын хүрээнд ЭМДЕГ-т аудит хийж, тус | **100.0** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах эзэн | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | газрын мэдээллийн санд зөрүүтэй мэдээлэл бүртгэсэн зөрчил илэрсэнд ХШҮДАГ-аас хяналт шалгалтыг хийж, тайланг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн байна. Албан шаардлагын дагуу хяналт шалгалтыг хийж, тайланг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 2/3010 дугаар албан бичгээр ҮАГ-т хүргүүлсэн.<br>ҮАГ-ын санхүүгийн тайлангийн аудитын системд "Санхүүгийн тайлангийн аудит"-аар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэн 2025 оны 05 дугаар сарын байдлаар ЭЭХХЗГ, ГССҮТ, УНТЭ, УГТЭ, ХТС, ЭМЯ, Эрүүл мэндийг дэмжих сангийн мэдээллийг баталгаажуулан https://fas.audit.mn цахим санд бүртгүүлсэн. Мэдээллийг Үндэсний аудитын газрын аудитор Ц.Сугармаа хянаж баталгаажуулсан. | |

| НИЙТ 18 АРГА ХЭМЖЭЭ | ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ | **88.6** |
|---|---|---|

## НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ 1)<br>Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх | | | | Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн 2024 оны шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан боловсруулсан. Үнэлгээний дүнг Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Хурлаас гарсан шийдвэрийг Дотоод меморандум №143-аар Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. | 2025.04 дүгээр сар | **100.0** |
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ 2)<br>УИХ-ын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын хэрэгжилтэд үнэлгээ хийх | | | | ЕТГ-ын даргын шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсгээс өгсөн үүргийн дагуу УИХ-ын "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 2022 оны 36 дугаар тогтоолоор ЭМЯ хариуцах арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны 3 дугаар сар болон 5 дугаар сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүн тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд оруулсан. ЗГХХГ-аас дээрх тогтоолын хэрэгжилтийн үнэлгээнд шаардлагатай байгаа нэмэлт мэдээллийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.<br>Уг тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх болох "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай", "Хүнсний тухай" хуулиудад заасан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлах дүрэм, журмыг яаралтай шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулах, эдгээр хуулиудад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцахаар заасан чиг үүргүүдийг хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар ТНБД-ын "Дотоод меморандум"-ыг 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр НЭМБГ-т хүргүүлсэн. | 2025 он 3-5 дугаар сар | **100.0** |
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ 4) | Хяналт шалгалтын тайлан | - | Хяналт шалгалтыг гүйцэтгэж, | Авлигатай тэмцэх газрын 2024 оны 05/20168 дугаар албан бичгийн дагуу СЭМҮТ-ийн 2024 оны 01-10 дугаар сарын хэвтэн эмчлүүлэх тасгийн төлбөртэй | 2025.01 сар | **100.0** |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хэвтэн эмчлүүлэх тасгийн 2024 оны төлбөртэй тусламж үйлчилгээнд хяналт шалгалт хийх | | | тайланг АТГ-т хүргүүлсэн байна. | тусламж үйлчилгээнд хяналт шалгалт хийж, дүнг 2025.01.21-ний өдрийн 8/330 дугаар албан бичгээр АТГ-т хүргүүлэв. Хяналт шалгалтын дүнд гэмт хэргийн шинж чанартай үйлдэл илэрсэн тул ЦЕГ-ын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Санхүү, татварын гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст 2025.01.21-ний өдрийн 8/329 дүгээр албан бичгээр хүргүүлэв. | | |
| 4 | Үүрэг даалгавар (арга хэмжээ 5)<br>Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2022- 2024 оны хэвтэн эмчлүүлэх тасгийн төлбөртэй тусламж үйлчилгээнд санхүүгийн хяналт, шалгалт хийж, шинжээчийн дүгнэлт гаргах | Шинжээч-дийн дүгнэлт | - | Шинжээ-чээр ажиллаж дүнэлт гаргасан байна. | Хэрэг бүртгэлийн 2050601093 дугаартай хэрэгт хохирлын үнэлгээ гаргах шинжээчээр ажиллаж СЭМҮТ-д 2022-2024 онд хэвтэн эмчлүүлж, төлбөр төлсөн иргэдийн хохирлын үнэлгээг хийсэн. Мөн шинжээчдийн дүгнэлтийг эцэслэн боловсруулж, ЦЕГ-ын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Санхүү, татварын гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст хүргүүлсэн. | 2025.3-4 сар | **100.0** |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Ёс зүйн сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан гэрчилгээ | - | Сургалтад хамрагдсан байна. | Удирдлагын академиас зохион байгуулсан “Төрийн албан хаагчдад зориулсан “Ёс зүй” анхан шатны цахим сургалтад 2025 оны 04 дүгээр сард хамрагдаж, гэрчилгээ (№719460) авсан. | 2025.... | **100.0** |

Төлөвлөгөөг үнэлсэн: ***Төсвийн шууд захирагч***

Төрийн нарийн бичгийн дарга ........................................................ /Д.Очирбат/
(албан тушаал) (гарын үсэг)

.............................. (огноо)

Тэмдэг

| | | | |
|---|---|---|---|
| Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:<br>Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын Халдварт өвчний хэлтсийн дарга<br>(албан тушаал) | Үнэлгээний багийн ахлагч<br>..........................................................<br>(гарын үсэг)<br>.............................. | /Д.Баярболд/<br><br>(огноо) | |
| Тайлагнасан:<br><br>Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга<br>(албан тушаал) | Нэгжийн дарга<br>..........................................................<br>(гарын үсэг) | /С.Төгсдэлгэр/ | 10.06.2025 (огноо) |

УДИРДЛАГЫН
АКАДЕМИ

# ҮНЭМЛЭХ

№ 719460

**Совд овогтой Төгсдэлгэр**

**Төрийн албан хаагчдад зориулсан “Ёс зүй” анхан шат**

ЦАХИМ СУРГАЛТАД АМЖИЛТТАЙ ХАМРАГДСАН ТУЛ ЭНЭХҮҮ ҮНЭМЛЭХИЙГ ОЛГОВ.

**Д.СҮРЭНЧИМЭГ**
*Доктор, дэд профессор*
Удирдлагын академийн
захирал

**Д.БАЙГАЛ**
*Доктор, профессор*
Удирдлагын академийн
Төрийн албаны сургуулийн захирал

2025.4